



Аудитын код: САГ-2017/32/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 260512 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа

Утас: 260512 Цахим хаяг: nyamdavaan@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Хөрөнгө оруулалтын зардлын дансны санхүүгийн тайлангийн талаар	8
2.9.2	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан тайлан, зөрчлийн талаар	9
2.9.3	Урьдчилгаа, авлагын талаар	9
2.9.4	Худалдан авах ажиллагааны талаар	10
2.9.5	Төсвийн гүйцэтгэлийн талаар	10
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	10
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	11
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	11
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
3.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан тайлан, зөрчлийн талаар	14
3.2	Урьдчилгаа, авлагын талаар	15
3.3	Худалдан авах ажиллагааны талаар	16
3.4	Төсвийн гүйцэтгэлийн талаар	17
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	18
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	18
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	19
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	21
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22

1 Аудитын гэрчилгээ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 764
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Эрчим хүчний сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд:

- Нийт 1,783.6 сая төгрөгийн автомашин, бараа материал, сэлбэг хэрэгсэлийг тендер зарлалгүй шууд болон харьцуулалтын аргаар худалдан авалт хийсэн байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0425SAG36.Docx

073214

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

- “Дулаан Шарын гол” ТӨХК, “Даланзадгадын ДЦС” ТӨХК, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК, “Диспетчерийн үндэсний төв” ХХК, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Сэргээгдэх эрчим хүчний төв” ТӨХК, “Ховд аймгийн ДС-ын АӨЗ” ТӨААТҮГ зэрэг байгууллагууд санхүүгийн тайлангийн аудитаар “хязгаарлалттай” дүгнэлт авсан.
- Өмнөх оноос авлага 24,372.8 сая төгрөгөөр, урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 14,892.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлийг эс тооцвол Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Эрчим хүчний сайд П.Ганхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлагнал, санал дүгнэлт, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2016 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Н.Нямдаваа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Эрчим хүчний сайдын 2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн а/965 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрчим хүчний яамны зорилго нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцөлийг хангахад оршино.

Эрчим хүчний сайд нь Эрчим хүчний яамыг тэргүүлж, эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их хурлын тогтоол болон бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангах, Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан:

- Эрчим хүчний нэгдсэн бодлого
- Эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал
- Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал
- Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого
- Түлш (эрчим хүч нүүрс)-ний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалтын асуудлыг хариуцсан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн ажлын хэсэг, тэргүүлж буй яамныхаа аппаратад түшиглэн эрхлэх асуудлынхаа хүрээний чиглэлээр зөвлөгөө, туслалцаа авч, яам агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байна” гэж заасны дагуу Эрчим хүчний сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай, Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Эрчим хүчний яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 10 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн тайланг нэгтгэхэд өртөг тооцох аргачлал, үйл ажиллагааны чиглэл ялгаатай зэрэг байдлыг харгалзан үзэж 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөхөөр шинэ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлуулан мөрдөж ажиллаж байна.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад тус яамны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас харьяа байгууллагуудад

төлөвлөгөөт аудитыг гүйцэтгэж байгаа боловч дотоод аудит хариуцсан 2 мэргэжилтэн байгаа нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудыг бүрэн хамруулахад хангалтгүй байна.

Тайланд онд Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны төсвийн урсгал зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалт зэрэгт, мөн үйл ажиллагааны хуваарийн дагуу харьяа 8 байгууллагын тухайн оны төсвийн төлөвлөлт, зарцуулалт, бүртгэл тайлагналын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж өгч ажилласан байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд харин санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан ТӨҮГ-ууд арилжааны банкаар дамжуулан ажил гүйлгээг хийж байна.

Улсын төсвөөс урсгал зардлын санхүүжилтад 19,934.6 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 19,641.5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 293.1 сая төгрөгөөр хэмнэсэн боловч Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт зардалд 126,707.1 сая төгрөг батлагдсанаас 129,287.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарч батлагдсан төсвийг 2,580.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байгаа нь гадаад эх үүсвэрээс санхүүжигддэг төсөл хөтөлбөрийн зардалтай холбоотой байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Эрчим хүчний сайд нь төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг www.energy.gov.mn веб хуудсанд "Шилэн данс" мэдээллийн самбарт холбогдох мэдээллүүдийг тухай бүр ил тод мэдээлж байна.

Түүнчлэн хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан 2016 оны 11 дүгээр сарын 21-нээс 12 дугаар сарын 02-ны хооронд Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний Төрийн өмчийн хувьцаат компани 28 /салбар болон охин компани/, аж ахуйн тооцоот газар 3, төсөл хөтөлбөр 12, төсвийн ерөнхийлөн захирагч зэрэг нийт 45 байгууллагын шилэн дансанд дотоод аудит хийж илэрсэн зөрчилд дүгнэлт өгч цаашид давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажилласан байна.

Эрчим хүчний яам өөрийн цахим хуудасны "Шилэн данс" цэсээр дамжуулан дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)

6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Эрчим хүчний яамтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд яамны аппарат, хөрөнгө оруулалтын зардлын данс, 27 төрийн өмчит хувьцаат компани, улсын үйлдвэрийн газар, 14 төсөл, хөтөлбөрийн нийт 42 тайлан нэгтгэгджээ.

Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор Амгалан дулааны станцыг Дулааны 4 дүгээр цахилгаан станц ТӨХК-ийн охин компани хэлбэрээр байгуулсан боловч санхүүгийн тайлангаа Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгүүлсэн байна.

Дээрх 42 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгдэхээс 9 төсөл хөтөлбөр болон зардлын 1 дансанд түүврийн аудит, 26 аж ахуй нэгж, байгууллагад хараат бус аудитын компани, 2 байгууллагад төрийн болон орон нутгийн аудитын байгууллага нийт 40 буюу 95.2 хувьд нь аудит хийж 8 байгууллагад “хязгаарлалттай”, 21 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгчээ.

Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй “Дарханы ДЦС-ын турбины шинэчлэл”, “Эрчим хүчний үр ашиг төсөл-II” төслүүд сангийн яамнаас шууд санхүүжилт хийгддэг гэсэн шалтгаанаар аудитад хамрагдаагүй байна.

2.9.1 Хөрөнгө оруулалтын зардлын дансны санхүүгийн тайлангийн талаар

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн уялдааг шалгах аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад Хөрөнгө оруулалтын зардлын санхүүгийн тайланд тухайн онд төлөгдсөн 22,841.3 сая төгрөгийн векселийн өглөгийг өмнөх оны

үр дүнд хаасан нь тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын хугацаанд дээрх ажил гүйлгээг залруулав.

2.9.2 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан тайлан, зөрчлийн талаар

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шууд захирагч, төрийн өмчит аж ахуй нэгж, төсөл хөтөлбөрүүд зэрэг байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн бүртгэл тайлагнал, авлага, өглөг, худалдан авах ажиллагаа, цалин хөлс, татварын тооцоолол, зарцуулалт, өмнөх аудитын зөвлөмж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчилд 18,014.9 сая төгрөгийн зөвлөмж, 1,146.3 сая төгрөгийн албан шаардлага, 18.6 сая төгрөгийн төлбөрийн акт тус тус тогтоосон байна

Шийдвэрлэсэн нь:

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг цаашид давтан гаргахгүй байх, акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг Эрчим хүчний яамны удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар “Дулаан Шарын гол” ТӨХК, “Даланзадгадын ДЦС” ТӨХК, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК, “Диспетчерийн үндэсний төв” ХХК, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Сэргээгдэх эрчим хүчний төв” ТӨХК, “Ховд аймгийн ДС-ын АӨЗахиргаа” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “..санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан.....албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн “Хязгаарлалттай” аудитын дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар албан шаардлага өгөх.

2.9.3 Урьдчилгаа, авлагын талаар

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 97,411.5 сая төгрөгийн авлагыг тайлагнасан нь өмнөх оноос 24,372.8 сая төгрөгөөр, урьдчилгаа дансны үлдэгдэл 66,741.5 сая төгрөг байгаа нь өмнөх үлдэгдлээс 14,892.2 сая төгрөгөөр тус тус өсч их хэмжээний авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дэх хэсэгт “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлж авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, цаашид авлага, өглөг үүсгэхгүй байх талаар зөвлөмж хүргүүлэв.

2.9.4 Худалдан авах ажиллагааны талаар

“Даланзадгадын ДЦС” ТӨХК, “Дулааны цахилгаан станц-2” ТӨХК, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК, “Хөвсгөл аймгийн ДС-ын АӨЗахиргаа ТӨААТҮГ”, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-иуд автомашин, бараа материал, сэлбэг хэрэгслийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.13, 7 дугаар зүйлийн 7.1, 49 дүгээр зүйлийн 49.2.10 зэрэг заалтууд болон нээлттэй тендер зарлалгүй шууд болон харьцуулалтын аргаар нийт 1,783.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил илэрсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

2.9.5 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Улсын төсвийн урсгал зардлыг 293.1 сая төгрөгөөр хэмнэсэн боловч Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт зардлыг 2,580.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байгаа нь гадаад эх үүсвэрээс санхүүжигддэг төсөл хөтөлбөрийн зардалтай холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг мөрдөж ажиллах.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 42 дугаар тогтоолын дагуу 2016 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайлан гаргах явцад Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн нийт 707,621.2 сая төгрөгийн хөрөнгө, өр төлбөр санхүүгийн тайланд тусгагдсан байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

- Сангийн яамнаас Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргах бэлтгэл ажилтай холбогдуулан өгсөн чиглэлийн дагуу тайлант жилд Эрчим хүчний сайдын төсвийн багцын санхүүгийн тайланд төрийн өмчит болон түүний оролцоотой үйлдвэрийн газруудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан. Санхүүгийн тайланг нэгтгэхэд өртөг тооцох аргачлал, үйл ажиллагааны чиглэл ялгаатай зэрэг байдлыг харгалзан үзэж 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөхөөр шинэ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлуулан мөрдөж байгааг үзэх болно.

- Цаг хугацаа, хүн хүчний боломжгүйгээс шалтгаалан Эрчим хүчний салбарын хэмжээнд хэрэгжиж буй хамтын хэлэлцээрийн талаар нарийвчлан судалж амжаагүй болно.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас төрийн өмчийн аж ахуй нэгжийн зорилтот түвшинг алдагдалтай байдлаар баталж өгдөг байдлыг нарийвчлан судалж үзэх.
- “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 26,323.8 сая төгрөгийн авлагын өсөлтийн талаар явцын аудитаар авч үзэх нь зохимжтой.
- Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж байгаа “Э-тайлан” програм хангамж хэвийн ажиллаагүй, санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлагнасан хөрөнгийн санхүүжилт, урсгал зардал, гадаад зээлийн санхүүжилт, нэмэлт санхүүжилт болон бусад холбогдох тооцоог Сангийн яамтай тооцоо бүрэн нийлж баталгаажуулаагүй,
- Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн “Э-тайлан” програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдсан зэрэг нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгээр системийн хэмжээнд 18.6 сая төгрөгийн акт, 1,146.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага тогтоосон байна. Нийт 93,629.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 74,449.3 сая төгрөгийн алдааг залруулж 18,014.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн в/1132 дугаар албан бичгийн хамт Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлаар сонгож түвшинг 2.0 хувиар буюу 35,341.2 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд тооцсон суурь болон түвшинд өөрчлөлт ороогүй болно.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дээрх зөрчлийг эс тооцвол Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Хязгаарлалтай” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

**3.1 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД
ХАМРАГДСАН ТАЙЛАН, ЗӨРЧИЙН ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шууд захирагч, төрийн өмчит аж ахуй нэгж, төсөл хөтөлбөрүүд зэрэг байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн бүртгэл тайлагнал, авлага, өглөг, худалдан авах ажиллагаа, цалин хөлс, татварын тооцоолол, зарцуулалт, өмнөх аудитын зөвлөмж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчилд 18,014.9 сая төгрөгийн зөвлөмж, 1,146.3 сая төгрөгийн албан шаардлага, 18.6 сая төгрөгийн төлбөрийн акт тус тус тогтоосон байна.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар “Дулаан Шарын гол” ТӨХК, “Даланзадгадын ДЦС” ТӨХК, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК, “Диспетчерийн үндэсний төв” ХХК, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Сэргээгдэх эрчим хүчний төв” ТӨХК, “Ховд аймгийн ДС-ын АӨЗ” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна.

Эрсдэлүүд

Дараах батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал- Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

ҮАГ-ын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг цаашид давтан гаргахгүй байх, акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг Эрчим хүчний яамны удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “.....санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан.....албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн “Хязгаарлалттай” аудитын дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар албан шаардлага өгөх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх **Төсвийн захирагчийн хариу** Асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан болно.

3.2 Урьдчилгаа, авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 97,411.5 сая төгрөгийн авлагыг тайлагнасан нь өмнөх оноос 24,372.8 сая төгрөгөөр, урьдчилгаа дансны үлдэгдэл 66,741.5 сая төгрөг байгаа нь өмнөх үлдэгдлээс 14,892.2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Их хэмжээний авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дэх хэсэгт “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлж авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, цаашид авлага, өглөг үүсгэхгүй байх талаар зөвлөмж хүргүүлэв.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Эрх ба үүрэг - Санхүүгийн тайлангийн дуусвар болсон өдөр хөрөнгө /авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан болно.

3.3 Худалдан авах ажиллагааны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

“Даланзадгадын ДЦС” ТӨХК, “Дулааны цахилгаан станц-2” ТӨХК, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК, “Хөвсгөл аймгийн ДС-ын АӨЗахиргаа ТӨААТҮГ”, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-иуд автомашин, бараа материал, сэлбэг хэрэгслийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.13, 7 дугаар зүйлийн 7.1, 49 дүгээр зүйлийн 49.2.10 зэрэг заалтууд болон нээлттэй тендер зарлалгүй шууд болон харьцуулалтын аргаар нийт 1,783.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил илэрсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал – Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан болно.

3.4 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Улсын төсвийн урсгал зардлыг 293.1 сая төгрөгөөр хэмнэсэн боловч Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт зардлыг 2,580.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байгаа нь гадаад эх үүсвэрээс санхүүжигддэг төсөл хөтөлбөрийн зардалтай холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал – Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулж баталгаажуулсан болно.

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/Мян.төг/	
Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015.12.31	2016.12.31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		215,519,465.6	1,156,146,443.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3a,3б	45,044,962.7	58,009,188.4
АВЛАГА	5a,5б,6a,6б	73,038,784.0	97,411,595.0
УРЬДЧИЛГАА	7a,7б	51,849,252.8	66,741,497.8
БАРАА МАТЕРИАЛ	8a,8б,8в	45,586,466.2	47,107,525.5
НӨӨЦИЙН БАРАА	9a	0.0	1,900,661.6
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		0.0	884,975,975.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,046,690,693.0	1,923,621,159.8
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11a,11б	0.0	15,467,352.3
Урт хугацаат зээл		0.0	15,467,352.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12a, 12б,12в	2,046,690,693.0	1,908,153,807.5
Биет хөрөнгө		2,038,475,918.5	1,898,451,576.2
Биет бус хөрөнгө	13.0	8,214,774.5	8,757,154.8
Бусад хөрөнгө /ТӨҮГ/		0.0	945,076.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,262,210,158.7	3,079,767,603.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР		553,221,649.2	577,569,510.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15a,15б	144,082,770.5	128,379,281.5
Богино хугацаат зээлийн өглөг	16a,16б	13,439,234.9	6,528,314.8
Өглөг	17a,17б	97,642,726.0	93,630,852.8
Урьдчилж орсон орлого	18a,18б	33,000,809.6	28,220,113.8
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19.0	409,138,878.7	449,190,228.7
Урт хугацаат зээл	20a, 20б	409,138,878.7	449,190,228.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,708,988,509.5	2,502,198,093.1
Засгийн газрын хувь оролцоо		1,708,988,509.5	2,502,198,093.1
Хуримтлагдсан үр дүн		-83,470,858.0	639,322,457.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		537,819,650.7	455,353,282.6
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		0.0	84,287.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,262,210,158.7	3,079,767,603.2

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015.12.31	2016.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		224,640,367.7	436,853,387.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а,1б	143,016,898.9	301,081,655.4
Нийтлэг татварын бус орлого		138,489,053.2	300,296,910.1
Тусламжийн орлого		4,527,845.7	784,745.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		81,623,468.8	136,895,899.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	163,016,701.7	282,652,333.4
УРСГАЛ ЗАРДАЛ		161,561,156.1	282,652,333.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		140,109,265.2	264,457,061.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,602,334.1	3,016,143.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		416,560.8	338,314.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		391,440.8	365,466.5
Хангамж, бараа материалын зардал		325,748.2	215,967.7
Нормативт зардал		357.7	245.0
Эд хогшил, урсгал засварын зардал		21,030.8	34,129.0
Томилолт, зочны зардал		587,132.4	242,689.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		132,246,354.3	138,573,657.5
Бараа үйлчилгээний бусад зардал		2,518,306.1	114,901,521.1
ТАТААС		20,050,000.0	16,849,933.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,401,890.9	1,345,338.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,455,545.6	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		61,623,666.0	155,325,221.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		57,021.5	6,354,615.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		8,692,190.4	44,590,161.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		52,988,497.1	117,089,675.6

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мян.төг/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2014 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	313,941,742.8	0.0	313,941,742.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	972,183,055.9	0.0	972,183,055.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,286,124,798.7	0.0	1,286,124,798.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	536,137,969.2	0.0	536,137,969.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-166,262,755.5	0.0	-166,262,755.5
Тайлант үеийн үр дүн	52,988,497.1	0.0	52,988,497.1
2015 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	1,708,988,509.5	0.0	1,708,988,509.5
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,708,988,509.5	0.0	1,708,988,509.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	602,174,752.8	0.0	602,174,752.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,311,163,262.3	0.0	2,311,163,262.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-83,227,594.1	0.0	-83,227,594.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	157,423,106.7	0.0	157,423,106.7
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-250,357.4	0.0	-250,357.4
Тайлант үеийн үр дүн	117,089,675.6	0.0	117,089,675.6
2016 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	2,502,198,093.1	0.0	2,502,198,093.1

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мян.төг/

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,286,628,186.0	2,020,379,438.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,187,749,472.5	1,864,579,706.4
Нийтлэг татварын бус орлого	1,183,221,626.8	1,863,794,961.1
Тусламжийн орлого	4,527,845.7	784,745.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	98,878,713.4	173,085,286.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,122,288,579.8	1,784,837,753.7
УРСГАЛ ЗАРДАЛ	1,122,288,579.8	1,784,837,753.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,083,582,172.3	1,742,144,172.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,572,858.3	155,236,049.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,905,765.8	43,403,784.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,763,035.0	14,297,299.8
Хангамж, бараа материалын зардал	276,016,534.8	822,679,816.6
Нормативт зардал	353.9	2,703.3
Эд хогшил, урсгал засварын зардал	34,347.7	39,948.5
Томилолт, зочны зардал	578,914.5	243,408.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	612,036,940.0	704,781,990.8
Бараа үйлчилгээний бусад зардал	1,673,422.4	1,459,171.8
ТАТААС	20,050,000.0	16,849,933.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,656,407.5	25,843,647.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	164,339,606.1	252,827,239.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	6,796,310.1	3,324,747.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	138,337,684.6	199,788,945.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	138,337,684.6	199,788,945.8
Дотоод эх үүсвэрээр	138,337,684.6	199,788,945.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-131,541,374.5	-196,464,198.1
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-17,225,257.3	-43,398,815.6
Бусад эх үүсвэр	27,517,666.0	7,599,737.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	6,948,860.9	27,424,702.5
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	37,794,062.4	23,573,850.3
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	15,572,974.3	12,964,225.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,471,988.4	45,044,962.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,044,962.7	58,009,188.4

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	126,707,069.0	129,287,287.6	-2,580,218.6	102.0
УРСГАЛ ЗАРДАЛ	21,645,674.8	20,104,359.3	1,541,315.5	92.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,632,171.5	3,109,789.2	1,522,382.3	67.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,362,017.4	1,362,017.4	0.0	100.0
Үндсэн цалин	1,043,133.5	1,043,133.5	0.0	100.0
Нэмэгдэл	245,241.1	245,241.1	0.0	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	73,642.8	73,642.8	0.0	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,040.8	140,040.8	0.0	100.0
Тэтгэврийн даатгал	100,325.2	99,563.2	762.0	99.2
Тэтгэмжийн даатгал	7,943.2	8,095.2	-152.0	101.9
ҮОМШӨ-ний даатгал	9,928.9	9,041.8	887.1	91.1
Ажилгүйдлийн даатгал	1,985.7	3,101.0	-1,115.3	156.2
Эрүүл мэндийн даатгал	19,857.8	20,239.6	-381.8	101.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,341.3	73,211.1	9,130.2	88.9
Гэрэл, цахилгаан	41,508.7	46,287.6	-4,778.9	111.5
Түлш, халаалт	34,535.6	21,258.9	13,276.7	61.6
Цэвэр, бохир ус	6,297.0	5,664.7	632.3	90.0
Байрны түрээс	0.0	0.0	0.0	0.0
Хангамж, бараа материалын зардал	47,779.5	47,571.0	208.5	99.6
Бичиг хэрэг	13,472.8	13,479.3	-6.5	100.1
Тээвэр, шатахуун	8,240.5	8,240.5	0.0	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,260.6	18,074.1	186.5	99.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,623.8	1,623.8	0.0	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,181.8	6,153.2	28.6	99.5
Нормативт зардал	2,805.0	2,703.3	101.7	96.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,805.0	2,703.3	101.7	96.4
Эд хогшил, урсгал засварын зардал	25,538.0	19,933.8	5,604.2	78.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,205.4	1,205.4	0.0	100.0
Урсгал засвар	24,332.6	18,728.4	5,604.2	77.0
Томилолт, зочны зардал	35,938.7	31,650.7	4,288.0	88.1
Дотоод албан томилолт	35,938.7	31,650.7	4,288.0	88.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	346,941.5	88,807.9	258,133.6	25.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	320,130.0	65,231.2	254,898.8	20.4
Тээврийн хэрэгслийн татвар	4,760.0	4,760.0	0.0	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,333.9	9,933.4	400.5	96.1
Газрын төлбөр	1,717.6	0.0	1,717.6	0.0

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,000.0	8,883.3	1,116.7	88.8
Бараа үйлчилгээний бусад зардал	2,588,769.3	1,343,853.2	1,244,916.1	51.9
Бараа үйлчилгээний бусад зардал	2,588,769.3	1,343,853.2	1,244,916.1	51.9
ТАТААС	16,850,000.0	16,849,933.3	66.7	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	16,850,000.0	16,849,933.3	66.7	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,503.3	144,636.8	18,866.5	88.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,000.0	3,112.5	887.5	77.8
Бусад урсгал шилжүүлэг	159,503.3	141,524.3	17,979.0	88.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	61,049.1	43,070.1	17,979.0	70.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	98,454.2	98,454.2	0.0	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	88,253,989.0	81,758,225.7	6,495,763.3	92.6
Барилга байгууламж	85,136,318.0	81,758,225.7	3,378,092.3	96.0
Тоног төхөөрөмж	935,700.0	0.0	935,700.0	0.0
Бусад хөрөнгө	2,181,971.0	0.0	2,181,971.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	16,807,405.2	27,424,702.5	- 10,617,297.3	163.2
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	16,807,405.2	27,424,702.5	- 10,617,297.3	163.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	126,707,069.0	129,287,287.6	-2,580,218.6	102.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	104,601,086.8	101,077,839.7	3,523,247.1	96.6
Улсын төсвөөс санхүүжих	104,601,086.8	101,077,839.7	3,523,247.1	96.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,807,405.2	27,424,702.5	- 10,617,297.3	163.2
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	16,807,405.2	27,424,702.5	- 10,617,297.3	163.2
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	5,298,577.0	784,745.3	4,513,831.7	14.8
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	5,298,577.0	784,745.3	4,513,831.7	14.8
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	191.0	191.0	0.0	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	0.0	100.0
Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	95.0	95.0	0.0	100.0
Удирдах ажилтан	13.0	17.0	-4.0	130.8
Гүйцэтгэх ажилтан	68.0	66.0	2.0	97.1
Үйлчлэх ажилтан	14.0	12.0	2.0	85.7
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	95.0	95.0	0.0	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	77.0	77.0	0.0	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	2.0	2.0	0.0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.0	14.0	0.0	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	2.0	2.0	0.0	100.0